

Эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан заавар  
**ФАРМАТЕКС**

Бүртгэлийн дугаар: F971212GP00195

Худалдааны нэршил: ФАРМАТЕКС

Олон улсын нэршил: Бензалконийн хлорид

Химийн нэршил: Диметил-алкил-бензил-аммонийн хлорид

Эмийн хэлбэр: Утэрэний тос

Найрлага: 100 гр тосонд:

Идэвхитэй бодис: 1,2 гр бензалконийн хлоридтой тэнцэх 50%-ийн 2,4 гр бензалконийн хлоридийн усан уусмал.

Туслах бодис: Нимбэгний хүчил, макроголь 300 болон 1500, этиленгликолийн стеарат (Тефоз 63), нил цэцгийн охь, цэвэршүүлсэн ус 100 гр хуртэл.

Гадаад байдал: Нил цэцгийн үнэртэй цагаан крем

Эмийн эмчилгээний бүлэг:

Жирэмслэлтээс хамгаалах хэсэг газрын үйлчилгээтэй эмийн бэлдмэл.

АТС код: G02BB

Эм судалалын опцлог: Бензалконийн хлорид нь спермицид болон антисептик үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлдэг. Үйлчлэгч бодис нь эр бэлгийн эсийн мембраниг гэмтээдэг. Эр бэлгийн эсийг 2 шаттайгаар гэмтээнэ: эхлээд сүүл хэсгийг, дараа нь толгой хэсгийг гэмтэснээр үр тоогох чадваргүй болгодог. Фарматексийг хэрэглэснээр жирэмслэх эрсдэлийг нэлээд хэмжээгээр бууруулах боловч энэ эрсдэлийг бүрэн арилгадаггүй байна. Эмнэлзүйн үр дүн нь Перлийн индексээр тодорхойлогдох ба бэлдмэлийг зөв хэрэглэсэн тохиолдолд уг индекс 1-ээс багагүй байна. In vitro бэлдмэл нь бэлгийн замаар дамжих халдвируудын олон төрлийн үүсгэгч тэр дундаа гонококк, хламид, герпес вирусын 2-р хэлбэр, хүний дархалын хомдолын вирус, үтэрэний трихомонал, алтлаг стафиллококкийн эсрэг үр дүнтэй.

Бэлдмэл нь микоплазмд үйлчлэхгүй ба Gardnerella vaginalis, candida albicans, Haemophilus ducrey, treponema pallidum-д сул үйлчилгээ үзүүлнэ.

In vivo бэлгийн замаар дамжих зарим нэг халдвараас урдчилан сэргийлэх үйлчилгээтэй боловч батлагдаагүй байна.

Бэлдмэл нь үтэрэний микрофлор, тэр дундаа Дедерляны савханцарт нөлөөлөхгүй.

**Фармакокинетик:** Бензалконийн хлорид нь үтэрэний салстаар шимэгдэхгүй. Утэрэний ханын гадаргуу дээр шингэх ба срдийн физиологийн ялгадасын хамт гадагшилдаг эсвэл усаар угаахад арилдаг.

**Хэрэглэх заалт:** Нөхөн үржихүйн насны, эсрэг заалтгүй бүх эмэгтэйчүүдэд зориулсан хэсэг газрын үйлчилгээтэй жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл бөгөөд дараах тохиолдолуудад хэрэглэж болно:

-Жирэмснээс хамгаалах эм уух эсвэл умайд ерөндөг тавиулах боломжгүй, хугацааны болон үнэмлэхүй эсрэг заалтгтай үед

-Хүүхэд торүүлсний дараа, хөхүүл үед

-жирэмслэлт тасалсаны дараа

-Цэвэршилтийн урьдал насны хүмүүст

- Тогтмол бус, тодорхой хугацаанд жирэмслэлтээс хамгаалах шаардлагатай тохиолдолд

-Жирэмслэлтээс хамгаалах бэлдмэл байнга уудаг хүмүүс зангарлах болон эмээ марсан үедээ хэрэглэнэ.



Үтрээний халхавч болон умайн ерөндөг хэрэглэж байгаа эмэгтэйчүүд стероид бус үрэвслийн эсрэг эм бэлдмэл хэрэглэсэн тохиолдолд нэмэлтээр жирэмслэхээс хамгаалах зорилгоор хэсэг газрын үйлдэлтэй бэлдмэлийг хэрэглэж болно.

**Хориглох заалт:**

- Сэтгэцийн өөрчлөлттэй эсвэл бэлэг эрхтэндээ гадны зүйл хүргэдэггүй хүмүүс Фарматексийг зөв хэрэглэх боломжгүй ба жирэмслэхээс хамгаалах хэрэгслийт хэрэглэхэд саад учруулдаг.
- Ийм хэлбэрийн хамгаалах аргыг зөвшөөрдөггүй эсвэл ойлгох чадваргүй хүмүүс
- Эмийн найрлаганд орсон аль нэг бодист хэт мэдрэг байх
- Утрээний үрэвсэлтэй бол
- Умай болон үтрээний салстын цочирсон болон шархалсан үед хэрэглэхгүй.

**Хэрэглэх арга:** Утрээнд хийж хэрэглэнэ. Тунлагч хэрэгслийг тос бүхий савны амсарт байрлуулан, хий оруулахгүйгээр тоскоор дүүргэнэ (цагираг тэмдэглэл эсвэл бүлүүрийн эцэс хүргэл). Дараа нь хэмжигч хэрэгслээ савнаас салгах ба бэлгийн харьцаанд орохын өмнө түүний бүлүүрийг удаан түлхэн үтрээнд тосыг гүн байрлуулна. Хэмжигч хэрэгслийг гаргана. Хэвтээгээр байрлуулах нь хялбар. Хамгаалах үйлчилгээ тэр даруйдаа эхлэх ба доод тал нь 10 цаг үргэлжилнэ. Давтан бэлгийн харьцаанд орох бүрдээ тосыг заавал шинээр хэрэглэх хэрэгтэй.

**Нэг удаагийн тун:** Нэг бэлгийн харьцаанд нэг тун тос байхаар тооцсон. Үйлчлэгч бодис хувь хүнд таарч байгаа эсэх болон бэлгийн харьцааны давтамжаас бэлдмэлийн хэрэглээ хамаарна. Ерөндөг болон үтрээний халхавчтай хамт хэрэглэж болно.

**Гаж нөлөө:** Бэлдмэлийн найрлага дахь бодист харшилах /хорсох, загатнах/, контактный дерматит илэрч болзошгүй. Эдгээр шинжүүд илэрвэл фарматексийг хэрэглэхээ зогсоондоо.

**Тун хэтрэлт:** Тун хэтэрсэн шинж тэмдэглэгдээгүй.

**Бусад эмийн бэлдмэлтэй харилцан нөлөөлөл:** Утрээгээр хэрэглэдэг эм бэлдмэлтэй хамт хэрэглэхгүй. Утрээгээр хэрэглэдэг ямарч эм хэрэгсэл Фарматексийн эр бэлгийн эс үхүүлэх үйлчилгээг идэвхигүй болгоно. Саван Фарматексийг задалдаг. Саван болон түүний үлдэгдэл үйлчлэгч бодисыг устгадаг учир бэлгийн харьцааны өмнө болон хойно үтрээгээ савангаар угаахгүй байх шаардлагатай.

**Анхааруулга:** Жирэмслэхээс хамгаалах үйлдэлийн үр дун нь хэрэглэх зааврыг чанд мөрдхөөс хамаарна.

- Бэлгийн харьцаа болгоны өмнө хэрэглэнэ.
- Давтан бэлгийн харьцаа бүрийн өмнө заавал тосны шинэ тун хэрэглэнэ.
- Хэмжигч хэрэгслийг түүнд агуулагдах тос үтрээнд аль болох гүн орохоор байрлуулах хэрэгтэй бөгөөд хэвтээ байрлал илүү тохиромжтой.
- Бэлгийн харьцаанд орохын 2 цагийн өмнө, мөн түүнээс хойш 2 цагийн турш бэлэг эрхтэнээ савангаар угаахыг хориглоно, учир нь бага хэмжээний савангийн үлдэгдэл ч Фарматексийн үйлчлэгч бодисыг идэвхигүйжүүлнэ.
- Бэлгийн харьцааны дараа зөвхөн цэвэр усаар эсвэл Фарматексийн саван агуулаагүй, бензалконийн хлорид бүхий хөөсөрдөг уусмалаар бэлэг эрхтэний гадна талыг угаана. Бэлгийн харьцаанаас хойш 2 цагийн дараа үтрээгээ угааж болно.
- Фарматексийг үтрээнд хийсэн үед ванн, нуур далайн ус, бассейн, усан санд орж болохгүй бөгөөд жирэмслэхээс хамгаалах үйчилгээг бууруулах аюултай.
- Фарматекс бензалконийн хлорид агуулдаг учир үтрээний ямар нэг эмгэг үүсэх эсвэл сэдрэх тохиолдолд хэрэглэхээ зогсоох шаардлагатай.

0905/1

- Утэрээний өвчнийг эмчлэх ба/эсвэл утэрээгээр эм бэлдмэл хэрэглэх шаардлагатай тохиолдолд эмчилгээ дууссаны дараа Фарматексийг хэрэглэнэ.

**Жирэмсэн болон хөхүүл үед:**

Жирэмсэн үед хэрэглэхэд ямар нэг хортой нэлээ илрээгүй байна; үйлчлэгч бодис болон түүний эцсийн бүтээгдэхүүн урагт сөрөг нэлөө үзүүлдэггүй гэдэг нь туршилтаар харуулсан байна. Үүнээс гадна судалгаагаар бензалконийн хлорид нь цусанд ордогтүй гэдгийг баталсан.

**Хөхүүл үед:** Энэхүү спермицид нь хөхний сүү болон цусанд нэвтэрдэггүй гэдэг нь батлагдсан тул хөхүүл үед хэрэглэхэд аюулгүй.

**Эмийн савлалт:** Полиэтилен зргэдэг тагтай, эпоксиfenолийн хамгаалагч лакан бүрхүүлгэй, хөнгөнцагаан гуурсан саванд 72 гр тос байх ба нэг цаасан хайрцагт хэрэглэх заавар, тунлагч хэрэгслийн хамт савлагдсан.

**Хадгалалт:** 25°C –аас ихгүй хэмд, хүүхэд хүрэхгүй газарт хадгална.

**Хадгалах хугацаа:** 3 жил. Хайрцган дээр заасан хугацаа хэтэрсон тохиолдолд хэрэглэхгүй.

**ЭМИЙН САНГААС ЖОРГУЙ ОЛГОНО.**

